БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

---

Дэлүүн сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код: БӨА-2022/61/НА-СТА-ТШЗ**

---

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Өлгий хот<br>2023 он | Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: М.Хуанган<br>Утас: 70422954 Цахим хаяг: khuanganm@audit.gov.mn<br>Аудитын менежер: Х.Женисбек<br>Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn<br>Ахлах аудитор: Д.Назгүл<br>Утас: 99427301 Цахим хаяг: nazgul_1972@yahoo.com |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу. .

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ ........ 3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ ........ 5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА ........ 16
4. АУДИТЫН ТАЙЛАН ........ 19
4.1 Ерөнхий зүйл ........ 19
4.2 Материаллаг байдал ........ 20
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт ........ 20
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ........ 22
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт ........ 22
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ........ 22
4.5.1 Завсрын аудитын талаар ........ 22
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал ........ 23
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ ........ 23
5.1 Төлбөрийн акт ........ 24
5.2 Албан шаардлага ........ 24
2. Үйлчилгээний албан хаагчдад ур чадварын үнэлгээ хийгээгүй, ур чадварын нэмэгдэл олгоогүй. ........ 24
5.3 Зөвлөмж ........ 24
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ ........ 25

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын стандарт |
| ҮАГ | Үндэсний аудитын газар |
| БСШУСС | Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд |

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,
Утас/Факс: (976) 7042-2954
E-mail: bayanulgii@audit.gov.mn

ДЭЛҮҮН СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН 1 ДҮГЭЭР СУРГУУЛИЙН ЗАХИРЛЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ А. ЖАНБОЛАТ ТАНАА

2023.02.15 № 59

танай____________-ны № ____________-т

**Хязгаарлалттай дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дэлүүн сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Дэлүүн сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

1. Бараа материалын бүртгэлийн журналуудыг хөтлөөгүй, нярав нь аж ахуй, бараа материалын тайланг зохих журмын дагуу сар бүр гаргаж тооцоо хийгээгүй, хагас, бүтэн жилээр нэгтгэж гаргасан.

2. Сургуулийн 2022 оны халаалтын зардлын батлагдсан төсөв 165,753.0 мянган төгрөг боловч захирал нь эрх мэдлээ хэтрүүлж гүйцэтгэгч компаниудтай 309,333.0 мянган төгрөгөөр гэрээ байгуулан оны эцэст 160,163.4 мянган төгрөгийн үндэслэлгүй өр үүсгэсэн зэрэг нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, 6.4.8, 16 дугаар зүйлийн 16.5.2, 16.5.4, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1, 4.1.3, 4.1.9, 15 дугаар зүйлийн 15.2, 15.2.1, 15.2.5, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, 5.1.4, 14 дүгээр зүйлийн 14.3, 14.3.2, 14.3.3, 14.4, 14.4.1, 14.4.5,14.4.6, 20.2.3, 20.2.6 гэсэн заалтууд АДБОУС 200, АОУС

250, УСНББОУС 1 стандартуудад нийцэхгүй, толилуулга, оршин байх, эрх ба үүрэг, нийцсэн бөгөөд зохистой байх. батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Төсвийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг хэрэгжүүлээгүй, нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүй байна.

**Аудитын гол асуудал**

2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд анхаарал татах дараах асуудлууд байна.

1. Бэлтгэн нийлүүлэгч компанид 2022 оны 9-12 дугаар сард үдийн хоолны төсвийг нэг хүүхдэд ноогдох нормативаар бүрэн шилжүүлж, үдийн хоолыг сургууль бэлтгэж, цалингийн зардлаас үр ашиггүй зардал гаргасан.

2. Батлагдсан орон тооны хязгаарыг 21 орон тоогоор хэтрүүлсэн.

**Бусад асуудлын хэсэг**

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР М.ХУАНГАН

Дүгнэлт-Дэлүүн ЕБС 1 хязгаарлалттай-2.15-2-ТА

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

**Төгрөгөөр**

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **110,390,024.30** | **213,236,322.07** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | - | 64,277,457.80 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | - | 64,277,457.80 |
| **3121** | **Төгрөг** | - | 64,277,457.80 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | - | 64,277,457.80 |
| **33** | **АВЛАГА** | 10,600,000.00 | - |
| **335** | **Бусад авлага** | 10,600,000.00 | - |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 10,600,000.00 | - |
| **34** | **УРЬДЧИЛГАА** | - | 32,175,900.00 |
| 34600 | Урьдчилж гарсан зардал | - | 32,175,900.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 99,790,024.30 | 116,782,964.27 |
| **354** | **Хангамжийн материал** | 99,790,024.30 | 116,782,964.27 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 7,193,350.00 | 5,139,500.00 |
| 35420 | Аж ахуйн материал | - | 3,538,000.00 |
| 35460 | Хүнсний материал | 3,803,860.30 | 2,896,000.27 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 88,792,814.00 | 105,209,464.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **3,747,625,314.72** | **3,996,094,198.92** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 3,747,625,314.72 | 3,996,094,198.92 |
| **392** | **Биет хөрөнгө** | 3,687,075,314.72 | 3,935,590,032.27 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 3,945,940,126.00 | 4,125,740,126.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (501,862,530.80) | (527,335,527.40) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 21,000,000.00 | 21,000,000.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (21,000,000.00) | (21,000,000.00) |

| | | | |
|---|---|---|---|
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 204,276,792.67 | 287,652,429.07 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (180,142,372.07) | (182,892,186.80) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 200,865,291.00 | 200,865,291.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (113,860,954.90) | (120,553,787.35) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 130,491,890.00 | 148,491,890.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (51,127,306.68) | (55,776,294.75) |
| 39217 | Ном | 52,494,379.50 | 59,398,092.50 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 60,550,000.00 | 60,504,166.65 |
| 39301 | Програм хангамж | 550,000.00 | 550,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | - | (45,833.35) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 60,000,000.00 | 60,000,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **3,858,015,339.02** | **4,209,330,520.99** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **52,307,835.00** | **173,044,184.03** |
| **41** | **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | 52,307,835.00 | 173,044,184.03 |
| **413** | **Өглөг** | 52,307,835.00 | 173,044,184.03 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | - | 12,880,767.03 |
| **4136** | **Бусад өглөг** | 52,307,835.00 | 160,163,417.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 52,307,835.00 | 160,163,417.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **3,805,707,504.02** | **4,036,286,336.96** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 3,805,707,504.02 | 4,036,286,336.96 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 957,261,982.90 | 957,261,982.90 |
| 51101 | Өмч: - төрийн | 957,261,982.90 | 957,261,982.90 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 37,285,877.01 | 267,864,709.95 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 152,553,866.50 | 37,285,877.01 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | (115,267,989.49) | 230,578,832.94 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 2,811,159,644.11 | 2,811,159,644.11 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **3,858,015,339.02** | **4,209,330,520.99** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

**Төгрөгөөр**

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **3,101,107,970.00** | **4,123,180,349.40** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **2,285,000.00** | **12,000,000.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 2,285,000.00 | 12,000,000.00 |
| 120004 | Төсөвт байгууллагын өөрийн орлого | 2,285,000.00 | 12,000,000.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 2,000,000.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 2,285,000.00 | 10,000,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **3,098,822,970.00** | **4,111,180,349.40** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 2,838,152,110.00 | 3,762,022,449.40 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | - | 3,541,693,100.00 |
| 131005 | Хөрөнгийн санхүүжилт | 18,698,310.00 | 220,329,349.40 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 2,819,453,800.00 | - |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 12,789,860.00 | 2,809,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 1,504,860.00 | 1,849,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 11,285,000.00 | 960,000.00 |
| 131106 | Төсвийн урамшуулал | - | - |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 247,881,000.00 | 346,348,900.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 247,881,000.00 | 346,348,900.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **3,208,685,076.49** | **3,892,601,516.46** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **3,208,685,076.49** | **3,892,601,516.46** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 3,136,008,976.49 | 3,748,546,115.52 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 2,262,051,515.00 | 2,804,395,140.90 |
| 210101 | Үндсэн цалин | 2,073,573,915.00 | 2,278,914,040.90 |
| 210102 | Нэмэгдэл | - | 410,862,200.00 |
| 210104 | Урамшуулал | 115,873,000.00 | 114,618,900.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 72,604,600.00 | - |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 303,008,800.00 | 285,143,221.39 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 213,228,300.00 | 233,388,879.60 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 22,445,100.00 | 6,581,293.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 17,956,100.00 | 4,065,034.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 4,489,100.00 | 6,945,428.79 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 44,890,200.00 | 34,162,586.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 225,291,131.00 | 283,081,582.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 11,864,000.00 | 9,473,000.00 |
| 210302 | Түлш, халаалт | 213,427,131.00 | 273,608,582.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 19,803,092.00 | 11,728,836.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 4,815,660.00 | 4,380,136.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,362,500.00 | - |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,754,000.00 | - |
| 210404 | Ном, хэвлэл | 297,700.00 | - |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 2,700,000.00 | - |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 7,873,232.00 | 7,348,700.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 221,868,228.72 | 240,520,420.03 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 956,800.00 | 2,580,000.00 |
| 210502 | Хоол, хүнс | 196,616,428.72 | 237,940,420.03 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 24,295,000.00 | - |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 1,477,050.00 | 2,918,608.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,477,050.00 | 2,918,608.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 842,100.00 | - |
| 210702 | Дотоод албан томилолт | 842,100.00 | - |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 812,500.00 | 10,375,000.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 212,500.00 | 2,000,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 600,000.00 | - |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | - | 8,375,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 100,854,559.77 | 110,383,307.20 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | - | 48,022,492.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 3,629,650.00 | 22,750,350.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 97,224,909.77 | 39,610,465.20 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 72,676,100.00 | 144,055,400.94 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 72,604,200.00 | 143,292,950.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 72,604,200.00 | 143,292,950.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 71,900.00 | - |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 71,900.00 | - |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | - | 762,450.94 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | - | 762,450.94 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **(107,577,106.49)** | **230,578,832.94** |
| **145** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН** | - | - |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 7,690,883.00 | - |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 7,690,883.00 | - |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | (7,690,883.00) | - |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **(115,267,989.49)** | **230,578,832.94** |

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

**Төгрөгөөр**

| **Дансны код** | **Үзүүлэлт** | **Өмнөх оны гүйцэтгэл** | **Тайлант оны гүйцэтгэл** |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **3,080,124,660.00** | **3,892,851,000.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **-** | **2,000,000.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | - | 2,000,000.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | - | 2,000,000.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | | 2,000,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **3,080,124,660.00** | **3,890,851,000.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 2,819,453,800.00 | 3,541,693,100.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | | 3,541,693,100.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 2,819,453,800.00 | |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 12,789,860.00 | 2,809,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 1,504,860.00 | 1,849,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 11,285,000.00 | 960,000.00 |
| 131106 | Төсвийн урамшуулал | | |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 247,881,000.00 | 346,348,900.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 247,881,000.00 | 346,348,900.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **3,076,070,660.00** | **3,768,573,542.20** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **3,076,070,660.00** | **3,768,573,542.20** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **3,003,394,560.00** | **3,619,324,491.26** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 2,244,508,300.00 | 2,735,827,639.20 |
| 210101 | Үндсэн цалин | 2,056,030,700.00 | 2,210,346,684.90 |
| 210102 | Нэмэгдэл | | 410,862,114.30 |
| 210104 | Урамшуулал | 115,873,000.00 | 114,618,840.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 72,604,600.00 | |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 303,008,800.00 | 340,829,956.06 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 213,228,300.00 | 231,993,256.98 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 22,445,100.00 | 27,210,000.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 17,956,100.00 | 21,767,899.78 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 4,489,100.00 | 5,438,999.59 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 44,890,200.00 | 54,419,799.71 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 247,436,000.00 | 176,226,000.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 11,864,000.00 | 9,473,000.00 |
| 210302 | Түлш, халаалт | 234,872,000.00 | 165,753,000.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 700,000.00 | 1,000,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 12,769,160.00 | - |
| 210401 | Бичиг хэрэг | 1,611,760.00 | |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,362,500.00 | |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,082,400.00 | |
| 210404 | Ном, хэвлэл | 297,700.00 | |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 2,700,000.00 | |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,714,800.00 | |
| **2105** | **Нормативт зардал** | 175,420,100.00 | 236,648,670.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 956,800.00 | |
| 210502 | Хоол, хүнс | 168,375,900.00 | 236,648,670.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 6,087,400.00 | |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 1,000,000.00 | 1,100,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,000,000.00 | 1,100,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 842,100.00 | - |
| 210702 | Дотоод албан томилолт | 842,100.00 | |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,652,700.00 | 12,518,500.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,052,700.00 | 2,000,000.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 600,000.00 | |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | | 10,518,500.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 16,757,400.00 | 116,173,726.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | | 90,429,930.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 16,757,400.00 | 25,743,796.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **72,676,100.00** | **149,249,050.94** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 72,604,200.00 | 148,486,600.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 72,604,200.00 | 148,486,600.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 71,900.00 | - |

| | | | |
|---|---|---|---|
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 71,900.00 | |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | - | 762,400.94 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | | 762,400.94 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | - | 50.00 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | | 50.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **4,054,000.00** | **124,277,457.80** |
| | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | - | - |
| **4** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)** | - | - |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **4,054,000.00** | **60,000,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **4,054,000.00** | **60,000,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 4,054,000.00 | 60,000,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 4,054,000.00 | 60,000,000.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(4,054,000.00)** | **(60,000,000.00)** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | - | 64,277,457.80 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | 64,277,457.80 |

**2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

**Төгрөгөөр**

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | 957,261,982.90 | 2,824,479,307.11 | 139,234,203.50 | 3,920,975,493.51 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | 13,319,663.00 | 13,319,663.00 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **957,261,982.90** | **2,824,479,307.11** | **152,553,866.50** | 3,934,295,156.51 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | | -13,319,663.00 | -115,267,989.49 | -128,587,652.49 |
| C08 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **957,261,982.90** | **2,811,159,644.11** | **37,285,877.01** | 3,805,707,504.02 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| D01 | **2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **957,261,982.90** | **2,811,159,644.11** | **37,285,877.01** | 3,805,707,504.02 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | 0.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **957,261,982.90** | **2,811,159,644.11** | **37,285,877.01** | 3,805,707,504.02 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | | | 230,578,832.94 | 230,578,832.94 |
| D09 | **2022оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **957,261,982.90** | **2,811,159,644.11** | **267,864,709.95** | 4,036,286,336.96 |

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

**Төгрөгөөр**

| **Эдийн засгийн ангилал** | **Үзүүлэлт** | **Тайлант оны** | |
|---|---|---|---|
| | | **Батлагдсан төлөвлөгөө** | **Гүйцэтгэл** |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 3,890,042,000.00 | 3,825,002,141.26 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 3,890,042,000.00 | 3,825,002,141.26 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 3,735,948,000.00 | 3,676,515,541.26 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 2,765,557,200.00 | 2,735,827,639.20 |
| 210101 | Үндсэн цалин | 2,240,076,100.00 | 2,210,346,684.90 |
| 210102 | Нэмэгдэл | 410,862,200.00 | 410,862,114.30 |
| 210104 | Урамшуулал | 114,618,900.00 | 114,618,840.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 344,161,900.00 | 340,829,956.06 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 234,030,200.00 | 231,993,256.98 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 27,533,000.00 | 27,210,000.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 22,026,300.00 | 21,767,899.78 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 5,506,600.00 | 5,438,999.59 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 55,065,800.00 | 54,419,799.71 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 176,226,000.00 | 176,226,000.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 9,473,000.00 | 9,473,000.00 |
| 210302 | Түлш, халаалт | 165,753,000.00 | 165,753,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,000,000.00 | 1,000,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 258,025,800.00 | 236,648,670.00 |
| 210502 | Хоол, хүнс | 258,025,800.00 | 236,648,670.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 1,100,000.00 | 1,100,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,100,000.00 | 1,100,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 19,712,100.00 | 18,973,500.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,000,000.00 | 2,000,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 17,712,100.00 | 16,973,500.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 171,165,000.00 | 166,909,776.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 144,596,800.00 | 140,661,980.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 26,568,200.00 | 26,247,796.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 154,094,000.00 | 148,486,600.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 154,094,000.00 | 148,486,600.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 154,094,000.00 | 148,486,600.00 |
| **13** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 3,890,042,000.00 | 3,889,279,599.06 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 3,541,693,100.00 | 3,541,693,100.00 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 3,541,693,100.00 | 3,541,693,100.00 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 346,348,900.00 | 345,586,499.06 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 346,348,900.00 | 345,586,499.06 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 2,000,000.00 | 2,000,000.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 2,000,000.00 | 2,000,000.00 |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | 64,277,457.80 |
| **6** | **ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ** | | |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | 1 | 1 |
| 610001 | Төсвийн байгууллага | 1 | 1 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 199 | 220 |
| 620001 | Удирдах ажилтан | 1 | 1 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 115 | 126 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 67 | 77 |
| 620004 | Гэрээт ажилтан | 16 | 16 |

| | | | |
|---|---|---|---|
| **63** | **СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)** | 1,328 | 1,396 |
| **630** | **ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД** | 1,328 | 1,396 |
| 630001 | Төрийн өмчит ЕБС | 1,328 | 1,396 |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **199.00** | **220.00** |
| 650004 | СЄБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД) | 115.00 | 126.00 |
| 650009 | Тєрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 84.00 | 94.00 |

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

**Төгрөгөөр**

| **Дансны код** | **Үзүүлэлт** | **Гүйцэтгэл** |
|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | |
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **2,809,000.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **2,809,000.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 2,808,950.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 2,808,950.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,808,950.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 50.00 |
| **2133** | **Олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **50.00** |
| 213503 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг | 50.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 2,809,000.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 2,809,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 1,849,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 960,000.00 |
| **IV** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

***Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар***

Дэлүүн сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль нь ерөнхий боловсрол олгох чиг үүрэгтэй байгууллага. Сургууль нь 2022 онд "Хүүхдүүд амжилттай суралцахад бүх талын дэмжлэг үзүүлэх, хамтран ажиллах, хүүхдэд ээлтэй сургууль болох" зорилго дэвшүүлэн ажилласан байна.

Дээрх зорилгыг биелүүлэхээр дараах зорилтуудыг дэвшүүлэн ажилласан байна. Үүнд:

- Багш нарын салбар секцийн хамтран ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлэх, мэргэжлийн хөгжлийн бүлэг үүсгэж ажиллах
- Мэргэжлийн хөгжлийн бүлгийн нэг тэргүүн туршлагыг сургалт, үйл ажиллагаандаа нэвтрүүлэх
- Багш нарын ур чадварыг сайжруулахад анхаарах
- Хичээлийн судалгааг сар бүр зохион байгуулж, үр дүнг тооцож ажиллах
- Цахим хичээлийн сан бүрдүүлж medle.mn сайтад хичээл байршуулах
- Гүйцэтгэлийн үнэлгээнд суурилан сургуулийн болон багшийн төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэх
- Сургуулийн үйл ажиллагаанд эцэг эхийн оролцоог нэмэгдүүлэх
- Ахлах ангийн суралцагчдыг цахимаар хичээлээ сонгон судлах боломжийг бүрдүүлэх, цахимаар суралцах арга зүйд суралцуулах
- Хүүхдийг шим тэжээллэг хоол хүнс хэрэглэх зохистой дадал хэвшилд сургах, сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний чанарыг сайжруулах

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

***Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар***

Дэлүүн сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль нь Боловсролын тухай хууль, Бага, дунд боловсролын тухай хууль болон бусад боловсролын байгууллагуудад мөрдөж байгаа хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна.

Улсын Их Хурлаас Төсвийн тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдрийн хуулиар оруулсан өөрчлөлтөөр боловсролын салбарын байгууллагууд улсын төсвөөс санхүүжиж, БСШУС-ын харьяа Боловсролын ерөнхий газарт санхүүгийн тайлангаа нэгтгэлд тушаадаг болсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна гэж үзлээ.

Аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба нь тус аймгийн төсөвт байгууллагуудын санхүү, бүртгэлийн үйл ажиллагаанд хяналт тавих чиг үүрэг бүхий байгууллага юм. Дэлүүн сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль 2022 онд шалгалтад хамрагдаагүй тул дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дэлүүн сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

***Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар***

Дэлүүн сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль нь Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүй байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Дэлүүн сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 351.3 сая төгрөгөөр буюу 9.1 хувиар өссөн байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 0.00 | 64277.46 | 64,277.50 |
| Авлага | 10600.00 | 0.00 | -10,600.00 |
| Урьдчилгаа | 0.00 | 32175.90 | |
| Бараа материал | 99790.02 | 116782.96 | 16,992.90 |
| Үндсэн хөрөнгө | 3747625.31 | 3996094.20 | 280,644.80 |
| **Нийт хөрөнгө** | **3858015.34** | **4209330.52** | **351315.20** |
| Өр төлбөр | 52307.84 | 173044.18 | 120,736.30 |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 3805707.50 | 4036286.34 | 230,578.80 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **3858015.34** | **4209330.52** | **351315.10** |

*Эх сурвалж: Аудитын судалгаа*

Мөнгөн хөрөнгө, авлага, урьдчилгаа, бараа материал, үндсэн хөрөнгө, засгийн газрын хувь оролцоо дансуудад өмнөх оны үзүүлэлтээс нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна.

Мөнгөн хөрөнгийн данс оны эцэст 64.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарсан нь цалин, НДШ, нормативт зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр, хураамжийн зардал,

бараа үйлчилгээний зардал, үдийн цайны зардлуудыг хэмнэлттэй зарцуулсантай холбоотой ба үүнээс цалин, НДШ-ийн зардлын хэмнэлт 32.3 сая төгрөг байна.

Авлага данс оны эхэнд 10.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй байсныг тайлант онд барагдуулсан байна.

Тайлант онд цахим худалдан авалтаар гэрээ байгуулж, тоног төхөөрөмжийг хүлээж аваагүй байхад авснаар бүртгэж тайлагнасныг урьдчилж төлсөн зардлаар бүртгүүлж тайланд залруулга хийлгэсэн.

Бараа материалын данс 16.9 сая төгрөгөөр нэмэгдсэн нь аж ахуйн болон бусад хангамжийн материалын үлдэгдэл нэмэгдсэнтэй холбоотой ба тайлант онд 11.8 сая төгрөгийн бусад хангамжийн материал үнэ төлбөргүй хүлээн авсан байна.

Үндсэн хөрөнгийн данс 280.8 сая төгрөгөөр нэмэгдсэн нь тайлант онд төсвийн хөрөнгөөр 92.2 сая, үнэ төлбөргүй 228.1 сая төгрөгийн хөрөнгө хүлээн авч үндсэн хөрөнгөнд тайлант онд 39.6 сая төгрөгийн элэгдэл байгуулсантай холбоотой байна.

Өр төлбөр дансны үлдэгдэл 173.0 сая төгрөг болж 120.6 сая төгрөгөөр нэмэгдсэн байна. Өр төлбөр нэмэгдэхэд шинээр хувь хүний орлогын албан татварт 12.8 сая, НДШ-д 0.06 сая, түлш халаалтын зардалд 160.2 сая төгрөгийн өглөг шинээр үүсгэсэн нь нөлөөлсөн байна.

Тайлант онд 230.6 сая төгрөгийн үр дүнтэй ажилласантай холбоотой Засгийн газрын хувь оролцоо данс 230.6 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 3,990.4 сая, орон нутгийн төсвөөс 139.2 сая , нийт зарлагыг 4,129.6 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Дээд шатны төсвийн захирагчаас төсвийг хянаж Төсвийн төслийн саналаас 373.1 сая төгрөгөөр бууруулж 3,756.5 сая төгрөгөөр баталсан байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсөвт хэд хэдэн удаа тодотгол хийж төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 9 арга хэмжээг санхүүжүүлэхээр 3541.7 сая төгрөгийг улсын төсвөөс, 346.3 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 2.0 сая төгрөгийг үндсэн үйл ажиллагааны орлогоос бүрдүүлэхээр тусгасан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 3,541.7 сая төгрөгийн, орон нутгийн төсвөөс 346.3 сая төгрөгийн санхүүжилт олгосон ба үндсэн үйл ажиллагааны орлогоос 2.0 сая төгрөг оруулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,299.9 сая төгрөг буюу 98.4 хувьтай байгаа нь бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний зардлын төсвийг 0.4 сая, үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 35.6 сая төгрөгөөр хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил үйлчилгээний зардлын зориулалт | 353,433.70 | 352,671.30 | -762.40 | 99.78% |
| 2 | Бараа үйлчилгээний бусад нийтлэг зардлын зориулалт | 3,542.40 | 2,876.00 | -666.40 | 81.19% |
| 3 | Эрүүл мэндийн арга хэмжээ | 8,147.60 | 8,147.60 | 0.00 | 100.00% |
| 4 | Үдийн цай | 154,094.00 | 148,486.60 | -5,607.40 | 96.36% |
| 5 | Дотуур байрны үйлчилгээ | 419,256.00 | 397,878.80 | -21,377.20 | 94.90% |
| 6 | Хүүхдэд ээлтэй орчин | 85,415.00 | 85,415.00 | 0.00 | 100.00% |
| 7 | Боловсролын байгууллагын багш, ажиллагсдын мэргэжил дээшлүүлэх | 15,940.90 | 13,542.60 | -2,398.30 | 84.96% |
| 8 | Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө, хөтөлбөрийг хэрэгжүүлэх | 2,327,133.80 | 2,293,775.60 | -33,358.20 | 98.57% |
| 9 | Сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах | 523,078.60 | 523,078.60 | 0.00 | 100.00% |
| | **Дүн** | **3,890,042.00** | **3,825,872.10** | **-64,169.90** | **98.35%** |

*Эх сурвалж: Аудитын судалгаа*

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Дэлүүн сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль 2022 онд аймгийн дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид олгох төсвөөс 1,8 сая, төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 1.0 сая, нийт 2.8 сая төгрөгийн эх үүсвэр бүрдүүлж, бараа үйлчилгээний зардалд 2.8 сая төгрөгийг зарцуулж, орон нутгийн төсөвт 50 төгрөгийг төвлөрүүлсэн байна.

### *3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн*

Дэлүүн сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургууль 2022 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Дэлүүн сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн

байгууллагын үйл ажиллагааг сайжруулах хууль тогтоомжийн хэрэгжилт, бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Назгүл гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн.

Дэлүүн сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 06-ны өдрийн 01/03 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

**4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Дэлүүн сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 3208.7 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 48.1 сая төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэх үе шатанд материаллаг байдлыг Дэлүүн сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 3,892.6 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 58.4 сая төгрөгөөр шинэчлэн тогтоов.

Дэлүүн сумын Ерөнхий боловсролын 1 дүгээр сургуулийн 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал өмнөх оноос 683.9 сая төгрөгөөр нэмэгдсэн тул материаллаг байдлыг шинэчлэн тогтоох нь зүйтэй гэж үзсэн.

**4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага бараа, ажил үйлчилгээний зардлыг хэмнэлттэй зарцуулсан байна. Тухайлбал: Цалингийн зардлыг 28.9 сая, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 3.3 сая, нормативт зардлыг 21.4 сая, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 0.7 сая, бараа үйлчилгээний бусад зардлыг 4.2 сая, үдийн хоолны зардлыг 5.6 сая, нийт 64.3 сая төгрөгөөр хэмнэж зарцуулсан байна.

*Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад дараах алдаа, зөрчил илэрч төлбөрийн акт тогтоов. Үүнд:*

1. Тус сургуульд нярваар ажиллаж байгаад тэтгэвэрт гарсан иргэнд тэтгэвэрт гарахад нэг удаа олгох тэтгэмжийг олгож, цалингийн зардлаас 0.6 сая төгрөгийн нэг удаагийн тэтгэмжийг давхар олгосон.

*Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад дараах алдаа, зөрчил илэрч 2 албан шаардлага өгсөн. Үүнд:*

1.БСШУС-ын сайд, Сангийн сайдын хамтарсан 2018 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн А/024/11 дүгээр тушаалаар баталсан “Төрийн болон орон нутгийн өмчийн ерөнхий боловсролын сургуулийн багшаас бусад, захиргааны удирдлага, боловсролын бусад ажилтны орон тооны жишиг норматив”-ыг зөрчиж хичээл зохицуулагчийн орон тоо, болон архив, бичиг хэргийн орон тоог илүү ажиллуулж 13.4 сая төгрөгийн үргүй зардал гаргасан.

2. Батлагдсан орон тооны хязгаарыг хэтрүүлж англи хэлний багш 1, математикийн багш 3, хөдөлмөрийн багш 1, биеийн тамирын багш 3, бага ангийн багш 3, номын санч 1, хичээл зохицуулагчийн 1, архив бичиг хэргийн 1, дотуур байрны багш 2, дотуур байрны жижүүр 5, нийт 21 орон тоог илүү ажиллуулж үргүй зардал гаргасан.

3. Сумын төсөвт байгууллагууд нэгдсэн халаалтад холбогдсон, сургуулийн хичээлийн байранд 2014 оноос “Жанат” ХХК-тай гэрээ байгуулан халаалт авч ирсэн ба 2019 онд гэрээний хугацаа дууссан байна. Сургуулийн зүгээс шинэчлэн гэрээ байгуулаагүй тул “Жанат” ХХК 2020 оны 08 дугаар сарын 24-ний өдөр гэрээ байгуулах санал хүргүүлэх тухай ж/37 тоот “хариу ирүүлээгүй тохиолдолд Иргэний хуулийн 196 дугаар зүйлийг 2-т зааснаар гэрээ байгуулахаар дуугүй хүлээн зөвшөөрсөн гэж үзнэ” албан тоот хүргүүлж сургуулийн хичээлийн байрыг нэгдсэн халаалтаар хангаж ирсэн байна. Энэ хугацаанд сургуулийн зүгээс “Жанат” ХХК-тай гэрээ байгуулаагүй боловч 18729.1 м3 халаалтын эзлэхүүнтэй хичээлийн байранд 1м3-ыг 1298 төгрөгөөр тооцож халаалт авч сард 24.3 сая, жилийн дүнгээр 102.7 сая төгрөг төлж, оны эцэст өмнөх оны өр 42.9 сая төгрөгийг нэмж тооцоход нийт 122.5 сая төгрөгийн өртэй гарсан байна.

4.Сургууль нь 4 дотуур байр болон халуун усны байрыг нэгдсэн халаалтад холболгүй “Ел-арасан” ХХК-тай гэрээ байгуулан энгийн халаалт авч ирсэн байна. “Ел-арасан” ХХК-тай 2022 оны 1 дүгээр сарын 16-ны өдөр 3 жилийн хугацаагаар гэрээ байгуулж, 1м3-ыг 1350 төгрөгөөр тооцож 14726.05 м3 эзлэхүүн бүхий халаалтын талбайд сарын 19.8 сая төгрөгийн, жилийн 139.1 сая төгрөг төлөхөөр тусгасан. Халаалтын гэрээг жил бүр шинэчлэн хийж, оны эцэст дүгнэж байх ёстой тул энэхүү гэрээг хууль бус гэж үзэх үндэслэлтэй байна. Түүнчлэн сарын 19.8 сая төгрөгөөр гэрээ байгуулж, 12 галчын цалинг сургуулийн төсвөөс цалинжуулж, сар бүр “Ел-арасан” ХХК-д 11.4 сая төгрөг буюу жилийн дүнгээр 63.0 сая төгрөгийг халаалтын зардалд шилжүүлсэн. Оны эхний 9.3 сая төгрөгийн өрийг нэмж тооцоход оны эцэст 37.3 сая төгрөгийн өртэй гарчээ. 2022 онд 75а дотуур байр ажиллаагүй боловч “Еларасан” ХХК-нд халаалтын зардалд гэрээний дагуу бүрэн төлсөн байна. “Еларасан” ХХК-ны захирал нь тус сургуулийн нярав байгаа нь ашиг сонирхлын зөрчилтэй бөгөөд сургууль нь үр ашиггүй гэрээ байгуулан ажилласан байна.

5. Сургуулийн 2022 оны халаалтын зардлын батлагдсан төсөв 165.7 сая төгрөг боловч захирал нь эрх мэдлээ хэтрүүлж халаалтын зардалд 309.3 сая төгрөгөөр гэрээ байгуулан оны эцэст 160.1 сая төгрөгийн үндэслэлгүй өр үүсгэсэн.

6. Сумын Засаг даргын 2017 оны 09 дүгээр сарын 01-ний өдрийн 23 тоот захирамжаар сургуулийн халуун ус, бие засах газрын 252.2 м2, гал тогооны 292.3 м2, охидын дотуур байрны 528.6 м2, 75а байрны 1159.8 м2, 75 “б” байрны 1107.0 м2, нийт 3339.9 м2 газрыг “Ел-арасан” ХХК-д халаалтын зориулалтаар ашиглуулахаар хууль бусаар шилжүүлсэн байна.

7. Сургуулийн үдийн хоолыг гүйцэтгүүлэхээр 2022 оны 9-12 дугаар сард “Ай-арыс” ХХК-тай хүнсний материал бэлтгэн нийлүүлэх гэрээ байгуулж үдийн хоолны батлагдсан төсвийг 48120 хүүхэд өдөрт батлагдсан норматив 1500 төгрөгөөр тооцож 72.1 сая төгрөгийг шилжүүлсэн байна. Үдийн хоолыг сургуулийн цэвэрлэгч, туслах тогооч нарын 5-6 ажилтнаар гүйцэтгүүлж сургуулийн төсвөөс 13.0 сая төгрөгийг үр ашиггүй зарцуулсан байна. Үдийн хоолны гүйцэтгэгчээр гэрээ байгуулсан компани нь тус сургуулийн нярвын хамаарал бүхий этгээд байна.

8.Сургуулийн багш, ажилчдын цалин тогтоолтыг оны эхнээс шинэчлэн тогтоогоогүй.

9. Цалингийн ашгийн тооцоог буруу хийснээс хувь хүний орлогын албан татварт 12.8 сая төгрөгийн өртэй гарсан.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны мэдээллээс программд орсон мэдээллүүдийн хэрэгжилтийг шалгав.

Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын 1,213.3 сая төгрөгийн  орлого, зарлагын 53 мөнгөн гүйлгээг,  төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 4 шийдвэр гарсныг шилэн дансанд мэдээлээгүй байна. Шилэн дансанд мэдээлсэн байдлын хэрэгжилтийн хувь 0% байна.

Сургуулийн нягтлан бодогч 2022 оны 01 дүгээр сараас томилогдон ажилласан ба тус аудитын газраас 2022 оны 10 дугаар сард Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлээгүй тул сахилгын шийтгэл ногдуулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй байна гэж дүгнэлээ.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгасан дүнгээр албан шаардлага өгөв.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгдээгүй.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар санхүүгийн тайлангийн аудитаар Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар шилэн данстай холбоотой өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2, 6.4.4, 6.4.5, 6.4.6, 6.4.8  -д заасан 606.2 сая төгрөгийн 27 мэдээллийг байршуулаагүй, Өмнөх аудитаар илэрсэн зөрчлүүдийг арилгаж ажилласан, Засгийн газрын 2021 оны  43 дугаар тогтоолын 1.1-д заасная үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад  зардлын батлагдсан төсөв 31.9 сая төгрөгийн 10 хувь буюу 3.2 сая төгрөгийн хэмнэлт гаргаж ажиллаагүй зөрчлүүдийг арилгах

албан шаардлага, бараа үйлчилгээний зардлын гүйлгээг тооцоо үүсгэж, бүртгэж тайлагнах, шууд зардлаар бүртгэж тайлагнасан зөрчлийг арилгах талаар зөвлөмж өгсөн.

Аудитаар хэрэгжилтийг давтан шалгахад 33.3%-ийн биелэлттэй байна. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой болон шууд зардлаар бүртгэж тайлагнасан зөрчлийг тайлант онд давтан гаргасан байна.

*Хүснэгт 4* Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| **Үзүүлэлт** | **Өмнөх аудитын үзүүлэлт** | | **Биелэлт** | | |
|---|---|---|---|---|---|
| | **Тоо** | **Дүн** | **Тоо** | **Дүн** | **Хувь** |
| Акт | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Албан шаардлага | 2 | 609,391.0 | 1 | 3,191.0 | 50% |
| Зөвлөмж | 1 | 262,900.0 | 0 | 0 | 0% |
| **Нийт дүн** | **3** | **872,291.0** | **1** | **3,191.0** | **33.3%** |

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Энэхүү аудитаар сургуулийн өмч хөрөнгийн хадгалалт, ашиглалт, төсвийн зарцуулалтыг бүрэн шалгах боломжгүй тул эрсдэлтэй гэж сонгосон данс, ажил гүйлгээнүүдэд горим сорил хэрэгжүүлсэн. Гүйцэтгэлийн шалгалтаар өмч хөрөнгийн хадгалалт, ашиглалт, төсвийн зарцуулалтыг дэлгэрэнгүй шалгах шаардлагатай гэж үзэв.

Дараагийн аудитаар орон тооны гүйцэтгэл, хоол, үдийн цайны төсвийн зарцуулалт, бараа материалын тайлан гаргалт, тооллого, тооцоо хийсэн байдал, нягтлан бодох бүртгэлийн хөтлөлт, төсвийн зарцуулалтад тавьж буй дотоод хяналтын хэрэгжилтийг анхаарах шаардлагатай.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 86.5 сая төгрөгийн алдаа[1] илэрснээс аудитын явцад 86.5 сая төгрөгийн алдааг залрууллаа.

Үүнд: Санхүүгийн үр дүнгийн тайлангийн орлогыг 1.2 сая төгрөгөөр илүү, 28.2 сая төгрөгийн хөрөнгийн санхүүжилтийг туслах үйл ажиллагааны орлогоор тайлагнасан, бараа үйлчилгээний зардлыг 0.2 сая төгрөгөөр илүү тайлагнасан, Мөнгөн гүйлгээний тайлангийн үндсэн үйл ажиллагааны орлогыг 2.0 сая төгрөгөөр дутуу, бараа үйлчилгээний зардлыг 0.9 сая төгрөгөөр илүү, төвлөрүүлэх шилжүүлгийг 0.8 сая төгрөгөөр дутуу, биет ба биет бус хөрөнгө худалдан авах зардлыг 0.8 сая төгрөгөөр дутуу, бараа материалын тодруулга тайлангийн үнэ төлбөргүй орлогыг 10.0 сая төгрөгөөр алдаатай, бараа материалын тодруулга тайлангийн орлого ба зарлагын 10.2 сая төгрөгөөр алдаатай тайлагнаж ирүүлсэн, цахимаар худалдан авалтаар гэрээ байгуулж худалдан авсан боловч, бодитой хүлээж аваагүй 32.2 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг авснаар бүртгэж тайлагнасныг урьдчилж төлсөн зардалд бүртгүүлж аудитын явцад холбогдох тайлангуудад залруулсан.

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

Аудитаар нийтдээ 167.5 сая төгрөгийн зөрчил[2] илэрснээс, 2.7 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 182.3 сая төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага, 1 заалт бүхий зөвлөмж өгсөн.

### 5.1 Төлбөрийн акт

Аудитаар дараах зөрчлийн дүнгээр төлбөрийн акт тогтоосон.

1. Сургуулийн багш ажилчдад 4 дүгээр сард олгосон цалингаас 0.5 сая, 5 дугаар сард ажилчдад олгосон урамшууллаас 0.9 сая төгрөгийн татварыг дутуу суутгасан.

2. Сургуулийн ажилчдад 5 дугаар сард олгосон урамшуулалт цалингаас 1.0 сая төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийг ногдуулж суутгаагүй, нийгмийн даатгалын шимтгэлийн өр төлбөрийг санхүүгийн тайланд 0.3 сая төгрөгөөр дутуу тайлагнасан.

### 5.2 Албан шаардлага

Аудитаар дараах зөрчлүүдийн дүнгээр албан шаардлага өгөгдлөө.

1. Багш нарт ур чадвар олгох шалгуур үзүүлэлтийн дагуу хагас жил тутамд шалгуур үзүүлэлтэд заасны дагуу хамт олны оролцоог хангаж багш, ажилтны ур чадварыг үнэлж байх ёстой боловч хэрэгжүүлээгүй, үнэлгээ хийлгүйгээр нэг сургалтын менежер, нийгмийн ажилтан, 6 багшид 10.6 сая төгрөгийн ур чадварын нэмэгдэл олгосон.

2. Үйлчилгээний албан хаагчдын ур чадварын үнэлгээг жилийн турш хийгээгүй байна.

3. Бараа материалын бүртгэлийн журналуудыг тухай бүр хөтлөөгүй, нярав нь аж ахуй, бараа материалын тайланг зохих журмын дагуу сар бүр гаргаагүй, хагас, бүтэн жилээр хоёр удаа нэгтгэж гаргасан.

4. Түлш халаалт, гэрэл цахилгаан, тээвэр шатахуун, томилолт, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж, бараа үйлчилгээний бусад зардлын нийт 122.0 сая төгрөгийн гүйлгээг тооцооны дансаар дамжуулахгүйгээр шууд зардлаар бүртгэж тайлагнасан, өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлийг давтан гаргасан.

5. Цахим худалдан авалтаар авсан 32.1 сая төгрөгийн ухаалаг самбар, таблет, суурин компьютерийг хүлээж аваагүй байхад тооллогоор ирснээр бүртгэж, нягтлан бодох бүртгэлд тусгасан байна.

6.Сургуулийн дотуур байранд 2022 оны 1-12 дугаар сард байрлаж байсан хүүхдэд 63544 хүүхэд өдрөөр нийтдээ 237.3 сая төгрөгийн хүнсний материал зарцуулсан. Хүнсний материалыг Засаг даргын баталсан тус суманд мөрдөх зах зээлийн үнэ ханшаар, зарим бүтээгдэхүүнийг зах зээлийн ханшаас доогуур үнээр худалдан авсан боловч дотуур байрны хүүхдийн нэг өдрийн хоолны зардалд дунджаар 3736 төгрөг зарцуулж, нэг өдрийн хоолны зардлын норм 3475 төгрөгтэй харьцуулахад өдөрт 260 төгрөг 60 мөнгө буюу жилийн дүнгээр 16.5 сая төгрөгөөр нормативыг хэтрүүлж зарцуулсан.

7.Үдийн хоолны материалын нормативыг жилийн дүнгээр 0.9 сая төгрөгөөр хэтрүүлж зарцуулсан байна.

### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

---

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

### *1. Бүртгэл, тайлагналтай холбоотой асуудал*

*1.1Илрүүлэлт:*

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүй, сургуулийн удирдлага болон нягтлан бодогч нь санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар ойлголт, мэдээлэлгүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.9-д "нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг" гэж бүртгэлийн суурь, санхүүгийн тайлан гаргахад баримтлах зарчмыг тодорхойлсон журам, заавар, аргачлалыг багтаасан баримт бичгийг", 18 дугаар зүйлийн 18.2-т "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана" гэсэн заалттай нийцээгүй, АОУС-250-д "Санхүүгийн тайланд хууль тогтоомж, дүрэм, журмыг анхаарах", УСНББОУС-1, АДБОУС 200 болон нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй байна.

*2.2.Өгсөн зөвлөмж:*

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн хэрэгжилтийн хангаж нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулж санхүү, бүртгэл, тайлагналын үйл ажиллагаандаа ашиглах, байгууллагын удирдлага, нягтлан бодогч нар санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаарх мэдээлэл, ойлголтоо сайжруулах;

Дээрх зөвлөмжүүдийн биелэлтийг Төрийн аудитын байгууллагад 2023 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Санхүүгийн тайланг алдаатай илэрхийлсэн | 10 | 86475.9 | | | 10 | 86475.9 | 10 | 86475.9 | | | | |
| **Дүн** | **10** | **86475.9** | | | **10** | **86475.9** | **10** | **86475.9** | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | Үүнээс | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | Төлбөрийн акт | Албан шаардлага | Зөвлөмж | Хариуцлага тооцуулах албан шаардлага | Хууль, хяналтын байгууллагад шилжүүл |

| | | | | | | | | | | | | сэн асуудал |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Шалгуур үзүүлэлт хангаагүй багшид ур чадварын нэмэгдэл олгосон. | 1 | 10599.4 | | | 1 | 10599.4 | | | | | | |
| Бараа материалын тайланг зохих журмын дагуу сар бүр гаргаагүй | | | | | | | | | | | | |
| Зарим гүйлгээг тооцооны дансаар дамжуулахгүйгээр шууд зардлаар бүртгэж тайлагнасан | 1 | 154213.3 | | | 1 | 122037.4 | | | | | | |
| Цахим худалдан авалтаар авсан хөрөнгийг аваагүй байхад ирснээр бүртгэж, нягтлан бодох бүртгэлд тусгасан | | | | | | 32175.9 | | | | | | |
| Цалингаас 482.4 мянга, урамшууллаас 916.1 мянган төгрөгийн татварыг дутуу суутгасан. | 1 | 1398.5 | 1 | 1398.5 | | | | | | | | |
| Урамшууллаас 1053.5 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийг ногдуулж суутгаагүй, нийгмийн даатгалын шимтгэлийн 254.2 мянган төгрөгийн өглөгийг дутуу тайлагнасан. | 1 | 1307.7 | 1 | 1307.7 | | | | | | | | |
| Дотуур байрны хоолны нормативыг 16,561.6 мянган төгрөгөөр, үдийн хоолны материалын нормативыг 907.9 мянган төгрөгөөр хэтрүүлсэн | | 17,469.5 | | | 1 | 17,469.5 | | | | | | |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүй | 1 | | | | | | 1 | | | | | |
| **Дүн** | **4** | **184988.4** | **2** | **2706.2** | **2** | **182282.2** | **1** | | | | | |

## Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш 1,213,318.4 мянган төгрөгийн орлого, зарлагын 53 мөнгөн гүйлгээг, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах 4 шийдвэр гарсныг шилэн дансанд мэдээлээгүй | 1 | 1213318.4 | | | 1 | 1213318.4 | | |
| Дүн | 1 | 1213318.4 | | | 1 | 1213318.4 | | |
| Төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| Тэтгэвэрт гарсан няравт нэг сарын үндсэн цалинтай тэнцэх нэг удаагийн тэтгэмжийн олгосон | 1 | 620.5 | 1 | 620.0 | | | | |
| Жишиг норматив”-ыг зөрчиж хичээл зохицуулагчийн орон тоо, | 1 | 26194.7 | | | 1 | 13372.1 | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| болон архив, бичиг хэргийн орон тоог илүү ажиллуулж 13.4 сая төгрөгийн үргүй зардал гаргасан. | | | | | | | | |
| Батлагдсан орон тооны хязгаараас 21 орон тоог илүү ажиллуулсан. | | | | | | | | |
| Хувь хүний орлогын албан татварт 12,822.6 мянган төгрөгийн өртэй гарсан. | | | | | | 12822.6 | | |
| Сургуулийн багш, ажилчдын цалин тогтоолтыг хийгээгүй. | | | | | | | | |
| Дотуур байрнуудыг нэгдсэн халаалтад холбоогүй, дотуур байрны халаалтын байрны 3339.9м2 газрыг хувийн компанид шилжүүлсэн, халаалтын зардалд оны эцэст 160,163.4 сая төгрөгийн өртэй гарсан. Үдийн хоолны батлагдсан төсвийг гүйцэтгэгч компанид бүрэн шилжүүлсэн боловч үдийн хоолыг сургуулийн цэвэрлэгч, туслах тогооч нараар гүйцэтгүүлж өсвөөс 13,035.8 мянган төгрөгийг үр ашиггүй зарцуулсан | 1 | 173,199.2 | | | | 173,199.2 | | |
| Дүн | 3 | 200,014.4 | 1 | 620.5 | 2 | **199,393.9** | | |
| **Нийт дүн** | **4** | **1,413,332.8** | **1** | **620.5** | 3 | **1,412,712.3** | | |